

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

№	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хэрэгжилт, тайлан
1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө					
1.	Зорилго 2.1. 2.1.2. Төрийн албаны сул орон тооны талаарх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх.	2025	Сул орон тооны мэдээллийг цахим систем болон олон нийтэд ил тод байлгах.	Нийтэд ил тод мэдээллийг оруулсан байх.	Яамны хэмжээнд сул орон тооны мэдээллийг АҮЭБЯ-ны https://mmhi.gov.mn/%d1%85%d2%af%d0%bd%d0%b8%d0%b9-%d0%bd%d3%a9%d3%a9%d1%86/%d1%81%d1%83%d0%bb-%d0%be%d1%80%d0%be%d0%bd-%d1%82%d0%be%d0%be%d0%bd%d1%8b-%d0%bc%d1%8d%d0%b4%d1%8d%d1%8d%d0%bb%d1%8d%d0%bb/ тухай бүр оруулан ажиллаж байна.
2.	Зорилго 2.2 Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянах үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах.	2025	Шударга байдлын үнэлгээ.	Нийтэд ил тод мэдээллийг оруулсан байх.	2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 33 удаагийн албан бичгээр 30 албан хаагчийн /харьяа байгууллага болон компанийн ороогүй/ ХАСУМ-ийг хянуулахаар хүргүүлж шийдвэрлэсэн болно.
3.	Зорилго 2.5 Төрийн үйл ажиллагааны мэдээллийг цахимжуулах замаар иргэдийн мэдэх эрхийг баталгаатай эдлүүлэх.	2025	Цахим ил тод байдал.	Мэдээллийн ил тод байдлыг хангасан байх.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд Шил ажиллагааны систем (shilen.gov.mn) болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны вэбсайт (mmhi.gov.mn)-д АҮЭБЯ-ны 87 нэр төрлийн мэдээллийг оруулахад хяналт тавин байна. 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн ХЭГ/2545 тоот “Хуулийн биелэлтийг хангах тухай” албан бичгийн дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.” гэж заасны дагуу холбогдох мэдээллийг “shilen.gov.mn” сайтад хуульд заасан хугацаанд байршуулсан. 2022 оны Засгийн газрын 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх” журмын дагуу Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийсэн тайланг хавсралтын хамт хүргүүлсэн. Сайдын эрхлэх асуудлын харьяа байгууллагуудын шилэн дансны хуулийн 11 дүгээр сарын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Яамны нээлттэй ил тод байдлын

					үнэлгээ 50 хувьтай байсныг 2025 оны жилийн эцсийн үнэлгээг 90 хувь хүртэл ахиулсан.
4.	2.5.3. Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулах.	2025	Үйл ажиллагааны тайлан.	Бүрэн цахимжуулах.	Хүнд суртал, ашиг сонирхол болон авлигаас урьдчилан сэргийлэхээр цахим технологи нэвтрүүлж эрхлэх асуудлын хүрээнд яамнаас олгогддог тусгай зөвшөөрлийг “Зөвшөөрлийн цахим систем www.license.mn ” -д нэвтрүүлэн шатдаг хий, шатахуун, газрын тос, машины үйлдвэрлэл эрхлэх, төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх, үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх нийт 16 төрлийн тусгай зөвшөөрлийг цахимаар олгон ажиллаж байна.
5.	Зорилго 2.6.Салбарын авлигын эрсдэлийг оновчтой тодорхойлж түүнд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх.	2025	Шударга байдлын үнэлгээ.	2024 оны үнэлгээг ахиулсан байх.	<p>Монгол Улсын аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын авлигын эрсдэлийн үнэлгээнд дурдсан авлигын эрсдэлийн үнэлгээг сайжруулах зорилгоор Салбарын Төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагуудын (хоёр агентлаг) шударга байдлын үзүүлэлтүүдийг сайжруулах зорилгоор алба хаагчдын авлигын хор уршгийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, авлигад өртөх эрсдэлийг бууруулах, ажилдаа ёс зүйтэй хандах хандлагыг төлөвшүүлэх, ажлын байрны авлигын эрсдэлийг бууруулах, арилгах, авлигын эрсдэлгүй ажлын байр болгоход чиглэсэн жишиг үйл ажиллагаа хэрэгжүүлэх ажлуудыг хийж байна.</p> <p>Энэ хүрээнд “Олон нийтийн хяналт хэрэгжүүлэгч хууль ёс судалгааны төв”-тэй хамтран салбарын авлигын эрсдэлийн төсөөллийн судалгааг хийж үр дүнд дүн шинжилгээ хийсний дагуу авлигад өртөх эрсдэлийг бууруулах ажлын төлөвлөгөө гаргаж салбарын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудад “Хуулийн этгээдийн авлигаас сэргийлэх мэдлэг олгох” 3 үе шаттай сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн эхний 2 шатны сургалтыг зохион байгуулж дууссан. Уг сургалтын эхний 2 шатны сургалтад 95 салбарын ажилтан, албан хаагч оролцсон. Сургалтын үр дүнд Компаниуд авлигын эсрэг MNS ISO 37001-2024 Стандартын ойлголттой болж стандартын дагуу авлигын эсрэг дүрмийг компаниуд өөртөө авч хэрэгжүүлэх боломжтой бөгөөд дүрмийг сайжруулан боловсруулах ажлын дэд хэсгийг 6 компанийн төлөөлөлтэй хамтран зохион байгуулахаар ажиллаж байна.</p>
6.	4.2.4.7Уул уурхайтай холбоотой тусгай зөвшөөрөл олгох, сунгах цуцлахтай холбоотой улс, аймаг, сумдын удирдах байгууллагын эдлэх бүрэн эрх, хүлээх үүргийг тодорхой болгох.	2025	Эрх зүйн зохицуулалт хийх.	Баталсан хууль тогтоомж.	Эрдэс баялгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын 2025.03.19-ний өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдааны 13 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Улсын Их Хурлын даргын Захирамжаар байгуулагдсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт 2025 оны 04 дүгээр сарын

				<p>01-ний өдөр Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар танилцуулсан.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 16 өдрийн хуралдаанд танилцуулсан.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж, УИХ дахь Ажлын хэсэгт хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн.</p> <p>АМТХ-ийн 56.1.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан бол тусгай зөвшөөрлийг цуцална. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын талбайг ялгах үйл ажиллагааг Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлд хуульчилсан байдаг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайг солбицлоор тогтоож, тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр 45 хоног санал авдаг. • Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 заасны дагуу тухайн талбай байрших усны сав газрын захиргаанаас санал авах. (Тодорхой хуулийн хугацаа байхгүй тул 45 хоног жшиг болгон авдаг.) • Хуулиар хориглосон хязгаарласан талбайтай давхцалгүй, дээрх газруудаас санал авсан талбайг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр яамдаас санал авна. Яамдаас ирсэн саналын дагуу холбогдох хасалт хийж бэлтгэнэ. (АМТХ 17 дугаар зүйл) <p>Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.11-д “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбицлоор тогтоож, нийтэд мэдээлэх” гэж тусгасны дагуу асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын тогтоолоор тусгай зөвшөөрөл олгох талбайг тогтооно. (АМТХ 17.4 хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайд сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.)</p>
--	--	--	--	---

Зорилт 8.4 Байгалийн баялгийн орлого, үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх, иргэнд тэгш шударга хүртээх					
7.	Зорилт 8.4.4 Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх.	2025	Эрх зүйн зохицуулалт хийх.	Баталсан хууль тогтоомж	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ахлан ажиллаж байгаа бөгөөд тус яамнаас ажлын хэсэгт орж ажилласан. Яамны санал, дүгнэлтийг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн болно. Хууль зүй дотоод хэргийн яамнаас хариуцан хэрэгжүүлнэ.
2. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх					
8.	1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лэд дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх.	Тухай бүр	Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрд тайлагнадаг байх; - Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	А/ байгууллагын албан ёсны цахим хуудаст жилд 3-аас дээш контентыг түгээсэн байх. Б/мэдээлэл сурталчилгааны самбарыг улирал бүр шинэчилж ном, гарын авлагыг байршуулах.	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас 2025 онд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нэгтгэн тусгай төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажилласан. /Хавсралтаар төлөвлөгөөг хавсаргав/ Мэдээллийн ил тод байдлыг хангах асуудлаар: 2025 оны хагас жилийн байдлаар мэдээллийн ил тод байдал 50 хувьтай байсныг 2025 оны жилийн эцсийн байдлаар 90 хувь болгон ахиулсан. Яамны веб хуудсанд Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан контентуудыг байршуулсан. Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан 1 контентыг яамны зүгээс бэлтгэн гаргаж байршуулсан. /Хавсралт/ https://youtu.be/EW0TeA1iyFM
9.	1.2. Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах.	3 улиралд	- Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; - Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; - Үр дүнг тооцсон байх.	А/ нээлттэй хаалганы өдрөөр авлигын эсрэг зурагт хуудас, ном гарын авлагыг сурталчлах, өөрийн байгууллагын хууль дүрэм, ил тод байдлыг иргэдэд тайлбарлаж өгөх арга хэмжээ зохиох. Б/ оролцсон иргэдээс санал, хүсэлт, гомдлыг бүртгэн авах 50-	“Эрдэс баялгийн салбарын авлигын эсрэг манлайлал-шударга байдлын төлөөх амлалт” сэдвийн дор Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Эрдэс баялгийн салбарын төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэн, авлигын эрсдэлийг бууруулж, ил тод, хариуцлагатай засаглалыг төлөвшүүлэх манлайлалд уриалах өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд салбарын төрийн албан хаагчид болон төрийн өмчит компаниудын төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөлөл болсон 108 оролцогч хамрагдаж яамны Төрийн нарийн бичгийн даргын манлайллаар авлигын эсрэг асуудлыг институтийн түвшинд авч үзэх хандлага бэхжүүлэхээр зорилго болгосон.

				аас дээш иргэд оролцсон байх.	
10	1.3.Иргэдэд зориулсан өөрийн салбартай холбогдох цахим ном гарын авлага бүтээх, авлигын хор хөнөөлийг ойлгуулах, шүгэл үлээхийг уриалсан мэдээлэл, 110 дугаарыг сурталчлах.	Тухай бүр	- Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх; - Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; - Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	А/ Үзэлт 3000-аас дээш байх.	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, харьяа агентлаг болох Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн албанаас үзүүлж байгаа үйлчилгээний талаар танилцуулга брошюрыг бэлтгэн үйлчилгээ авагч байгууллагуудад тарааж мэдээллийг хүргүүлж байна. /Хавсралт зураг/
11	1.4 Өөрийн байгууллагын үйл ажиллагаа, авлигын хор хөнөөл, 110 тусгай дугаарыг сурталчилсан видео, контент бүтээх.	4 дүгээр улиралд	- Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; - Авлигын мэдээлэл 110 дугаарын утсыг сурталчилсан байх; - Олон нийтэд түгээсэн байх.	А/Үзэлт 3000-аас дээш байх. Б/ 4-өөс доошгүй байх.	https://mmhi.gov.mn/ яамны веб хуудсанд сурталчилгааны мэдээллийг байнга оруулан ажиллаж байна. Яамнаас гаргаж байгаа бүх хэвлэмэл хуудас танилцуулга материалуудад 1110 дугаарын мэдээлэл танилцуулгыг оруулж байгаа болно. /Хавсралт/
3.Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх					
12	2.1.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо,	Тухай бүр	- Салбарт бүрд үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын	Жилд 4 байгууллагатай хамтран ажилласан байх.	Нэгдсэн үндэсний байгууллагаас зарласан Эрдэс баялгийн салбарт шударга байдлыг бэхжүүлэх Интегра санаачилга төсөлд салбарын авлигын эсэг үйл ажиллагааг зохион байгуулах, үр дүнд хүргэх чиглэлээр 12 сэдвийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба,

	хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.		нэгдсэн судалгааг гаргасан байх; -Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх; - Үр дүнг тооцож, тайлагнасан байх.		<p>Авлигатай тэмцэх газар, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын тамгын газар, Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци, Монгол-Германы хамтарсан ашигт малтмалын технологийн их сургууль, Эдийн засгийн сэтгүүлч, шинжээчдийн клуб НҮТББ, Статистик хөтөч ТББ, Иргэний үндсэн эрх хөгжил ТББ-аас оролцож шалгарч тус тусын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас хэрэгжүүлж байгаа төсөл нь:</p> <p>1.Олборлох салбарын хуулийн этгээдийн авилгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах хөтөлбөр сэдвээр Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн авилгаас сэргийлэх дотоод дүрмийн төслийг дүрмийг боловсруулах, хэлэлцэх, батлах, 5 доошгүй тооны хуулийн этгээд дээр дүрмийг туршилтын журмаар мөрдүүлж эхлүүлэх зорилгоор;</p> <p>2. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалт, шийдвэр гаргах үйл явцыг ил тод болгох туршилт сэдвээр Аж үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн жишээн дээр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, салбарын компаниуд, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын оролцоотойгоор Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл болон түүний салбар зөвлөлүүдийн гишүүдийг сонгон шалгаруулах, шинжээч томилох, шийдвэр гаргах үйл явцын ил тод, нээлттэй байдлыг хангах замаар ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, жендерийн эрх тэгш байдлыг хангах, олон нийтийн хяналт, төр-иргэдийн итгэлцлийг бэхжүүлэх туршилтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх</p> <p>3. Монгол Улсын аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын авлигын эрсдэлийн үнэлгээнд дурдсан авлигын эрсдэлийн үнэлгээг сайжруулах зорилго бүхий Салбарын Төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагуудын (хоёр агентлаг) шударга байдлын үзүүлэлтүүдийг сайжруулах зорилгоор алба хаагчдын авлигын хор уршгийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, авлигад өртөх эрсдэлийг бууруулах, ажилдаа ёс зүйтэй хандах хандлагыг төлөвшүүлэх, ажлын байрны авлигын эрсдэлийг бууруулах, арилгах, авлигын эрсдэлгүй ажлын байр болгоход чиглэсэн жишиг үйл ажиллагаа хэрэгжүүлэх ажлуудыг хийж байна. Дээрх төслийн үр дүн 2026 онд гарна.</p>
13	2.2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийг өөрсдийн	Жилдээ	Тус хуулийн 8 дугаар зүйлд заасан арга хэмжээг		Хэрэгжилтийн байдлыг https://mmhi.gov.mn/ вэб сайтаар болон http://shilen.gov.mn сайтаас харж болно.

	цахим хуудсанд байршуулах.		хэрэгжүүлсэн байх.		
14	2.3.Байгууллагын цахим хуудсанд өөрчлөлт хийж иргэдийг мэдээлэл хайх, санал хүсэлт өгөхөд амар хялбар байдлаар өөрчлөх.	Жилдээ	Ойлгомжтой, хялбар байх.	Өөрчлөлт хийсэн байх.	Хэрэгжилтийн байдлыг https://mmhi.gov.mn/ вэб сайтаар мэдээллийг авч болно.
15	2.4.Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших.	Хагас бүтэн жилээр	Нийт ирсэн гомдлыг нэгтгэн дүгнэж тайлагнасан байх.	-Гомдлын агуулгыг багцлан ялгаж үр дүнтэй ямар арга хэмжээ хэрэгжүүлж хаасан талаар улирал бүр гаргах.	Хавсралтаар гомдлын мэдээ, тайланг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлснийг орууллаа. /Хавсралт/
16	2.5.Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх.	2, 4 дүгээр улиралд	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, дотоод хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах.	А/ Дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулж хэлтэс, алба бүрд дотоод хяналтын хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах. Б/ Илэрсэн зөрчил алдаа дутагдлыг авлигатай тэмцэх газарт тайлагнах.	2025 оны жилийн эцсийн байдлаар Авлигатай холбоотой гомдол мэдээлэл ирээгүй. Яамны газар, хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөлт түүний хэрэгжилтийн байдлыг холбогдох журмын дагуу үнэлгээг хийж Төрийн нарийн бичгийн даргын албан даалгавар гарган нийт албан хаагчдад хүргүүлэн ажиллаж байна. /Хавсралт албан даалгавар/

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ